



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/194/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Аудитор: Э.Энхбүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Enkhburene@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-19
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13-14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15-16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16-19
4. Аудитын тайлан	19-21
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20-21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УЦУОШТ	Ус цаг уур орчны шинжилгээний төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УС ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА О.ГАНБАТ ТАНАА

2025-02-13 № СЭА-2026/194/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төв нь ЦУОШГ-аас 101,222.0 мянган төгрөгийн ус судлалын автомат станц, эд хогшлын хамт шилжүүлэн авсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 131,776.9 мянган төгрөгийн конторын барилгын гадна их засварын ажлыг капиталжуулан бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд агаарын чанарыг хянах 24 цагийн бүрэн автомат станцтай болсноор агаарын хүхэрлэг хий, азотын давхар исэл, нарийн тоосонцрыг минут тутамд хэмжиж ард иргэдэд тухайн хугацааны бодит мэдээллийг цаг алдалгүй <https://agaar.gov.mn/> вэб сайтаас гар утас, компьютер ашиглан харах боломжийг бүрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г 4 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 96.5 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.


Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		126,491,381.1	162,963,352.6
33	АВЛАГА	5	-	24,286,837.0
33500	Бусад авлага		-	24,286,837.0
33510	Байгууллагаас авах авлага		-	24,286,837.0
35	БАРАА МАТЕРИАЛ	6	126,491,381.1	138,676,515.6
35100	Түүхий эд материал		57,059,548.2	62,382,276.6
35110	Тусгай зориулалттай материал		57,059,548.2	62,382,276.6
35400	Хангамжийн материал		69,431,832.9	76,294,239.0
35410	Бичиг хэргийн материал		323,200.0	291,850.0
35420	Аж ахуйн материал		24,353,162.9	23,122,039.0
35430	Сэлбэг хэрэгсэл		18,672,750.0	18,747,750.0
35440	Түлш, шатах тослох материал		1,475,000.0	3,866,000.0
35470	Бусад хангамжийн материал		24,607,720.0	30,266,600.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,169,875,925.8	1,335,524,043.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,169,875,925.8	1,335,524,043.5
39200	Биет хөрөнгө		907,945,425.7	1,074,023,543.3
39201	Барилга, байгууламж, орон сууц		516,075,687.1	647,852,574.1
39202	Хуримтлагдсан элэгдэл		(104,016,286.6)	(126,798,607.5)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		109,607,573.8	87,607,573.8
39204	Хуримтлагдсан элэгдэл		(94,129,156.7)	(59,112,085.7)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		696,163,169.3	752,155,734.3
39206	Хуримтлагдсан элэгдэл		(221,750,427.9)	(238,202,754.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		14,449,000.0	15,082,000.0
39208	Хуримтлагдсан элэгдэл		(8,454,133.4)	(4,560,891.4)
39300	Биет бус хөрөнгө		261,930,500.1	261,500,500.2
39301	Программ хангамж		1,775,000.0	1,775,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл		(352,499.9)	(782,499.8)
39303	Бусад биет бус хөрөнгө		260,508,000.0	260,508,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,296,367,306.9	1,498,487,396.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	5,120,535.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	5,120,535.8
41300	Өглөг	9	-	5,120,535.8
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		-	4,715,565.8
41360	Бусад өглөг		-	404,970.0
41361	Байгууллагад төлөх өглөг		-	404,970.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,296,367,306.9	1,493,366,860.3
51	Засгийн газрын хувь оролцоо		1,296,367,306.9	1,493,366,860.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,295,182,634.9	1,295,182,634.9
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		1,295,182,634.9	1,295,182,634.9
51200	Хуримтлагдсан үр дүн		(123,655,676.7)	73,343,876.7
51210	Өмнөх үеийн үр дүн		(479,052,168.7)	(123,655,676.7)
51220	Тайлант үеийн үр дүн		355,396,492.0	196,999,553.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		124,840,348.7	124,840,348.7

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,296,367,306.9	1,498,487,396.1
---	--	--	-----------------	-----------------



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан


/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	3,630,757,086.4	3,640,835,279.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		404,377,586.4	3,640,835,279.3
120	Нийтлэг татварын бус орлого		404,377,586.4	408,772,851.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,000,000.0	25,235,700.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,000,000.0	25,235,700.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		344,967,891.0	306,292,887.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		58,409,695.4	77,244,264.3
122	Тусламжийн орлого		-	3,232,062,428.0
1221	Хандив тусламж /дотоод/		-	3,232,062,428.0
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	3,200,846,000.0
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	3,200,846,000.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	31,216,428.0
122133	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		-	31,216,428.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	3,275,246,011.1	3,443,835,725.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,275,246,011.1	3,443,835,725.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,082,989,188.2	3,417,194,637.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,427,514,363.0	2,686,781,912.0
210101	Үндсэн цалин		1,354,046,098.0	1,464,733,775.0
210102	Нэмэгдэл		656,889,333.0	850,026,466.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		239,515,263.0	214,470,261.0
210104	Урамшуулал		177,063,669.0	157,551,410.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		303,597,792.0	335,186,644.0
210201	Тэтгэврийн даатгалын зардал		206,823,000.0	230,283,859.0

210202	Тэтгэмжийн даатгалын зардал	24,195,300.0	26,983,975.0
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	13,007,577.0	13,391,010.0
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	11,187,823.0	12,892,718.0
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	48,384,092.0	51,635,082.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,623,648.5	91,274,990.2
210301	Гэрэл, цахилгаан	18,317,500.0	24,086,693.7
210302	Түлш, халаалт	42,195,148.5	58,397,566.5
210303	Цэвэр, бохир ус	5,111,000.0	8,790,730.0
2104	Хангамж, бараа материалын зардал	39,693,324.8	38,756,395.1
210401	Бичиг хэрэг	2,311,000.0	3,594,193.0
210402	Тээвэр, шатахуун	19,959,500.0	20,915,549.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,824,208.6	3,845,114.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.0	300,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,789,898.5	4,281,790.0
210408	Бараа материал акталсны зардал	7,548,717.7	5,819,748.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,517,501.4	104,514,618.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,417,701.4	67,165,918.5
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	215,000.0	280,000.0
210604	Урсгал засвар	51,884,800.0	37,068,700.0
2107	Томилолт, зочны зардал	8,336,800.0	11,219,200.0
210702	Дотоод албан томилолт	8,336,800.0	11,219,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,418,445.0	6,074,108.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,688,080.0	4,466,453.0
210803	Даатгалын үйлчилгээ	355,500.0	628,590.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	313,107.0	333,765.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.0	99,000.0
210807	Газрын төлбөр	548,558.0	546,300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,428,033.6	143,386,769.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	960,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,428,033.6	142,426,769.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,256,822.9	26,641,088.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	26,641,088.8
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	26,641,088.8
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	26,641,088.8



2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал			-	26,641,088.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)			355,511,075.2	196,999,553.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)			355,396,492.0	196,999,553.4




2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,227,379,500.0	3,257,298,128.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.0	3,257,298,128.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.0	25,235,700.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.0	25,235,700.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.0	25,235,700.0
122	Тусламжийн орлого	-	3,232,062,428.0
1221	Хандив тусламж /дотоод/	-	3,232,062,428.0
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,200,846,000.0
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	3,200,846,000.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	31,216,428.0
122133	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	31,216,428.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,105,550,500.0	3,255,516,128.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,105,550,500.0	3,255,516,128.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,913,293,677.1	3,204,639,339.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,427,514,363.0	2,686,781,912.0
210101	Үндсэн цалин	1,251,650,900.0	1,464,733,775.0
210102	Нэмэгдэл	763,933,463.0	850,026,466.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	240,273,200.0	214,470,261.0
210104	Урамшуулал	171,656,800.0	157,551,410.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,597,792.0	335,237,781.0
210201	Тэтгэврийн даатгалын зардал	206,823,000.0	230,334,996.0
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	24,195,300.0	26,983,975.0
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	12,097,700.0	13,391,010.0
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	12,097,700.0	12,892,718.0
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	48,384,092.0	51,635,082.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,416,148.5	93,649,490.2

210301	Гэрэл, цахилгаан	18,317,500.0	24,070,193.7
210302	Түлш, халаалт	41,987,648.5	60,788,566.5
210303	Цэвэр, бохир ус	5,111,000.0	8,790,730.0
2104	Хангамж, бараа материалын зардал	30,130,428.6	24,155,898.0
210401	Бичиг хэрэг	2,046,400.0	2,047,100.0
210402	Тээвэр, шатахуун	19,692,000.0	16,108,328.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,824,208.6	3,618,270.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.0	300,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,307,820.0	2,082,200.0
2105	Нормативт зардал	3,859,280.0	2,960,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,960,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,493,500.0	46,024,700.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	982,500.0	5,910,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	209,400.0	560,000.0
210604	Урсгал засвар	28,301,600.0	39,554,700.0
2107	Томилолт, зочны зардал	8,336,800.0	8,779,200.0
210702	Дотоод албан томилолт	8,336,800.0	8,779,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,945,365.0	6,090,358.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,215,000.0	4,516,453.0
210803	Даатгалын үйлчилгээ	355,500.0	628,590.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	313,107.0	300,015.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.0	99,000.0
210807	Газрын төлбөр	548,558.0	546,300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	960,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	960,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,256,822.9	50,876,788.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	50,876,788.8
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	50,876,788.8
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	50,876,788.8
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	26,641,088.8
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	24,235,700.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	121,829,000.0	1,782,000.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	121,829,000.0	1,782,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	121,829,000.0	1,782,000.0

2200	Дотоод эх үүсвэрээр	121,829,000.0	1,782,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	121,829,000.0	1,782,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(121,829,000.0)	(1,782,000.0)



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нөөц	Бусад цэвэр хөрөнгө /өмч	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,295,182,634.9	124,840,348.7		(479,052,168.7)		940,970,814.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,295,182,634.9	124,840,348.7		(479,052,168.7)		940,970,814.9
Тайлант үеийн үр дүн	-	-		355,396,492.0		355,396,492.0
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,295,182,634.9	124,840,348.7		(123,655,676.7)		1,296,367,306.9
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,295,182,634.9	124,840,348.7		(123,655,676.7)		1,296,367,306.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,295,182,634.9	124,840,348.7		(123,655,676.7)		1,296,367,306.9
Тайлант үеийн үр дүн	-	-		196,999,553.4		196,999,553.4
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,295,182,634.9	124,840,348.7		73,343,876.7		1,493,366,860.3


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,223,974,200.0	3,226,081,700.0	(2,107,500.0)	100.1%
12	Татварын бус орлого	3,223,974,200.0	3,226,081,700.0	(2,107,500.0)	100.1%
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.0	25,235,700.0	(24,235,700.0)	2523.6%
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	1,000,000.0	25,235,700.0	(24,235,700.0)	2523.6%
122	Тусламжийн орлого	3,222,974,200.0	3,200,846,000.0	22,128,200.0	99.3%
122005	Төсвөөс санхүүжих	3,222,974,200.0	3,200,846,000.0	22,128,200.0	99.3%

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,223,974,200.0	3,175,204,911.2	48,769,288.8	98.5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,223,974,200.0	3,175,204,911.2	48,769,288.8	98.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,206,856,200.0	3,175,204,911.2	31,651,288.8	99.0%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,696,620,000.0	2,676,781,912.0	19,838,088.0	99.3%
210101	Үндсэн цалин	1,467,910,600.0	1,454,733,775.0	13,176,825.0	99.1%
210102	Нэмэгдэл	853,670,500.0	850,026,466.0	3,644,034.0	99.6%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	206,290,200.0	214,470,261.0	(8,180,061.0)	104.0%
210104	Урамшуулал	168,748,700.0	157,551,410.0	11,197,290.0	93.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	341,283,100.0	333,987,781.0	7,295,319.0	97.9%
210201	Тэтгэврийн даатгал	232,137,700.0	229,084,996.0	3,052,704.0	98.7%
210202	Тэтгэмжийн даатгал	27,311,800.0	26,983,975.0	327,825.0	98.8%
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,653,800.0	13,391,010.0	262,790.0	98.1%
210204	Ажилгүйдлийн даатгал	13,636,000.0	12,892,718.0	743,282.0	94.5%
210205	Эрүүл мэндийн даатгал	54,543,800.0	51,635,082.0	2,908,718.0	94.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,656,300.0	93,649,490.2	6,809.8	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	25,592,800.0	24,070,193.7	1,522,606.3	94.1%
210302	Түлш, халаалт	59,272,800.0	60,788,566.5	(1,515,766.5)	102.6%
210303	Цэвэр, бохир ус	8,790,700.0	8,790,730.0	(30.0)	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	13,772,100.0	13,489,470.0	282,630.0	97.9%
210401	Бичиг хэрэг	1,547,100.0	1,547,100.0	-	100.0%
210402	Тээвэр, шатахуун	6,741,900.0	6,741,900.0	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,535,000.0	3,318,270.0	216,730.0	93.9%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	365,900.0	300,000.0	65,900.0	82.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,582,200.0	1,582,200.0	-	100.0%
2105	Нормативт зардал	3,398,000.0	2,960,000.0	438,000.0	87.1%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,398,000.0	2,960,000.0	438,000.0	87.1%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,939,800.0	44,806,700.0	133,100.0	99.7%
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,692,000.0	7,692,000.0	-	100.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	560,000.0	560,000.0	-	100.0%
210604	Урсгал засвар	36,687,800.0	36,554,700.0	133,100.0	99.6%
2107	Томилолт, зочны зардал	3,135,800.0	2,779,200.0	356,600.0	88.6%
210702	Дотоод албан томилолт	3,135,800.0	2,779,200.0	356,600.0	88.6%

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,091,100.0	5,790,358.0	3,300,742.0	63.7%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,612,500.0	4,516,453.0	1,096,047.0	80.5%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	263,000.0	-	263,000.0	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	328,600.0	328,590.0	10.0	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,900.0	300,015.0	1,885.0	99.4%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	202,000.0	99,000.0	103,000.0	49.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,702,200.0	-	1,702,200.0	0.0%
210807	Газрын төлбөр	680,900.0	546,300.0	134,600.0	80.2%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	960,000.0	960,000.0	-	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	960,000.0	960,000.0	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,118,000.0	-	17,118,000.0	0.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,118,000.0	-	17,118,000.0	0.0%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,118,000.0	-	17,118,000.0	0.0%
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	50,876,788.8	(50,876,788.8)	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(50,876,788.8)	50,876,788.8	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(50,876,788.8)	50,876,788.8	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,876,788.8	(50,876,788.8)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	75.0	73.0	2.0	97.3%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0%
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	73.0	71.0	2.0	97.3%
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	70.0	68.0	2.0	97.1%
620003	Үйлчлэх ажилтан	2.0	2.0	-	100.0%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1.0	1.0	-	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.0	1.0	-	100.0%



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан




Дансны код	Дансны нэр, төрөл	Төгрөгөөр/ 1. Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,216,428.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,216,428.0
122	Тусламжийн орлого	31,216,428.0
1221	Хандив тусламж /дотоод/	31,216,428.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,216,428.0
350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,216,428.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,216,428.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,216,428.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,216,428.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,000,000.0
210101	Үндсэн цалин	10,000,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,250,000.0
210201	Тэтгэврийн даатгал	1,250,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10,666,428.0
210401	Бичиг хэрэг	500,000.0
210402	Тээвэр, шатахуун	9,366,428.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.0
210604	Урсгал засвар	3,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	6,000,000.0
210702	Дотоод албан томилолт	6,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь “Ус цаг уур орчны шинжилгээний үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах, байгаль цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргэмжлүүлэх, цаг агаар, уур амьсгалын нөөцийг бүрэн дүүрэн ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- 
- Улсын сүлжээний ус, цаг уурын өртөө харуулуудын тасралтгүй ажиллагааг хангаж, ус цаг уур орчны шинжилгээний хөтөлбөрт ажлыг нэгдмэл арга зүйн дагуу хийж гүйцэтгэх,
 - Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ган, цөлжилтийн эрсдэлийг бууруулах, таримал болон бэлчээрийн ургамлын ургацыг нэмэгдүүлэх, ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэхэд агаар мандлын үзэгдэл, процесст зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх, агаар, ус, хөрсний чанарт хяналт шинжилгээ хийх,
 - Ус цаг уур, орчны нийтийн мэдээгээр хэрэглэгчдэд шуурхай, чанартай үйлчлэх,
 - Хүрээлэн буй байгаль орчны төлөв байдалд хяналт тавьж үнэлэх, судлах ажлын хүрээг өргөжүүлэх,
 - Төсвийн тухай хуулийн хүрээнд төсөв санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах,
 - Байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа манлайллыг хангах,
 - Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитыг сайжруулах,
 - Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр Монгол Улсын Төсвийн тухай хуулиар төсөв, сахилга хариуцлагатай холбоотой, Төрийн албаны тухай хуульд хариуцлагатай холбоотой нэмэлт өөрчлөлт тус тус орсон,
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238, 239 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн гэх мэт.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ЦУОШГ-ын Захиргаа, аудитын хэлтсээс дотоод хяналт тавьдаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦУОШГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/163 дугаар тушаалаар Цаг уур, орчны шинжилгээний салбарын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 202,220.6 мянган төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	24,286.8	24,286.8
Бараа материал	126,491.4	138,676.5	12,185.1
Үндсэн хөрөнгө	1,169,875.9	1,335,524.0	165,648.1
Нийт хөрөнгө	1,296,367.3	1,498,487.4	202,120.0
Өр төлбөр	-	5,120.5	5,120.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,296,367.3	1,493,366.8	196,999.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,296,367.3	1,498,487.3	202,120.0

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна. Үүнд:

- Авлага 24,286.8 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөгөөнөөс давсан орлого 24,235.7 мянган төгрөг, НДШ-ын илүү төлөлт 51.1 мянган төгрөгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэнээс,

- Бараа материалын дансны үлдэгдэл 138,676.5 мянган төгрөг болж 12,185.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 76,388.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 2,775.0 мянган төгрөгийн шатахуун, ЦУОШГ-аас 74,469.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 5,819.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж, устган, 135,628.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,335,524.0 мянган төгрөг болж 165,648.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,782.0 мянган төгрөгийн багаж хэрэгслийг худалдан авч, ЦУОШГ-аас 101,222.0 мянган төгрөгийн багаж, техник хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн конторын барилгын гадна их засварыг капиталжуулан 131,776.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 33,806.3 мянган төгрөгийн эд хөрөнгийг акталсан болон 107,866.1 мянган төгрөгийн эд хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган 73,294.0 мянган төгрөгөөр дахин үнэлснээс,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 5,120.5 мянган төгрөгөөр өссөн нь тээвэр шатахууны 2,032.2 мянган төгрөгийн, албан томилолтын 2,440.0 мянган төгрөгийн, шуудан холбооны 243.3 мянган төгрөгийн, байгууллагад төлөх өглөг(бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс) 405.0 мянган төгрөгийн өр үүссэнээс тус тус шалтгаалсан байна.
- Санхүүгийн бүртгэлийн 1,500.0 мянган төгрөгийн Unicus программ хангамж, нярвын 275.0 мянган төгрөгийн Acolous программ хангамж биет бус хөрөнгөд бүртгэлтэй бөгөөд тайланд онд программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,321,910.9 мянган төгрөг, өөрийн орлогоос 1,800.0 мянган төгрөг буюу нийт 4,323,710.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 953,218.1 мянган төгрөгөөр бууруулж **3,370,492.8** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 668,051.4 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлыг 78,951.6 мянган төгрөгөөр,



- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23,005.3 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 27,818.7 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 8,341.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 54,973.0 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 55,426.7 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 20,628.4 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 6,122.0 мянган төгрөгөөр
- Ажил олгогчоос олгох тэтгэмжийг 9,900.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг нийт 5 удаа шинэчлэн 146,518.6 мянган төгрөгөөр бууруулж, **3,223,974.2** мянган төгрөг болгон эцэслэн баталсан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 14,328.7 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 698.0 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 62.5 мянган төгрөгөөр
- Ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 17,118.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 133,576.5 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлыг 17,046.3 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 3,603.1 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 18,657.2 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 4,302.7 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,540.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,222,974.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,200,846.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны өөрийн орлого 25,235.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,175,204.9 мянган төгрөг буюу 98.5 хувьтай тайлагнагдсан нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 31,650.5 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,203,743.7	3,172,093.2	31,650.5	99.0%
2	Холбооны суваг ашигласны хөлс	3,112.5	3,111.7	0.8	99.9%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	17,118.0	0.0	17,118.0	0.0%
	Дүн	3,223,974.2	3,175,204.9	48,769.3	98.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудитораас өгсөн “Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл”-ийн хүрээнд тус байгууллагаас авсан судалгаанд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- *УЦУОШТ-ийн даргын 2025 оны 01-р сарын 27-ны өдрийн А/05 дугаар албан бичгээр хоолны хөнгөлөлтийг аймгийн төвд 16.0 мянган төгрөг, сумдад 10.0 мянган төгрөгөөр тооцож, тайлант онд 214,470.3 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон,*
- *Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг онлайн болон танхимаар авч сургалтын төлбөрт 960.0 мянган төгрөгийн зардал гаргасан,*
- *ЦУОШГ-ын даргын А/162 тоот тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн 11.3 хувиар бууруулж 71 ажилтантайгаар баталсан,*
- *Гадаад томилолтоор ажиллаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулах зардал гараагүй, хэвлэл, мэдээллийн байгууллагаар гэрээт ажил гүйцэтгүүлээгүй байна.*

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130013404 тоот дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны санхүүжилт 30,000.0 мянган төгрөг, хөрсний чийгийн явуулын судалгааны шатахуунд 1,216.4 мянган төгрөг зэрэг нийт **31,216.4** мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, санхүүжилтийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх тус төвийн 131,776.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Конторын барилгын гадна засвар”-ын

худалдан авах ажиллагааг төрийн Худалдан авах ажиллагааны газраар харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

“Конторын барилгын гадна засвар”-ын худалдан авах ажиллагаанд хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Онцот баянхайрхан” ХХК шалгаран, гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.



4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 07/42 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,275,246.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32,752.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус төв нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:



- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээ/ERP/-г ашигласан,
- Сул орон тоонд шинээр ажилтан томилогдоогүй бөгөөд цалингийн зардлыг хэмнэсэн,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал олгоогүй,
- Сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэдээлбэл зохих 171 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төсвийг бодитойгоор төлөвлөх албан шаардлагыг биелэлтийг нотлох баримттай тулган шалгахад бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	8,874.0	1	8,874.0	100
Нийт дүн	1	8,874.0	4	8,874.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- ЦУОШГ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/214 дугаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны ажил үүргийг хавсран гүйцэтгүүлэх тухай” тушаалаар тус төвийн дарга О.Ганбатад сар бүр 40 хувиар тооцон, нийт 1,989.9 мянган төгрөгийн цалин олгосон байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар тайлант оны 25 ширхэг тавилга, аж ахуйн эд хогшлын элэгдлийг тооцоолоогүйгээс 100.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал дутуу тайлагнасан алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт **89,969.6** мянган төгрөгийн зөрчил² илэрч, зөвлөмж өгөв.

5.1 Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **52** нэр төрлийн **89,969.6** мянган төгрөгийн хөрөнгийг /Нийт хөрөнгийн 6 хувь/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг дахин үнэлэх болон актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				
	Дүн		Дүн		Дүн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тооцооллын алдаанаас хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцож тайлагнасан	1	100.6						1	100.6		
Дүн	1	100.6						1	100.6		

/Мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөр-ийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Тоо		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийг дахин үнэлээгүй	1	89,969.6					1	89,969.6				
Нийт дүн	1	89,969.6					1	89,969.6				

/Мянган төгрөгөөр/

Үүнээс